



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 1195

Тавин

Бүх нийтийн их цэвэрлэгээ  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.12 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн бүх нийтийн их цэвэрлэгээг 2023 оны 10 сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.
2. Цэвэрлэгээнд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага өөрсдийн эзэмшил газраас 50м зайд цэвэрлэгээ хийх, оршин суугаа бүх иргэд өөрийн өмч, эзэмшил, ашиглалтанд байгаа газар болон орчны цэвэрлэгээнд хамруулсугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга, Байгаль орчны мэргэжилтэн нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

